



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2015 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 5/50

Улаанбаатар хот

О.Батмөнхийг ажилд томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Нийслэлийн Засаг Даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалт, Нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөлийн 2015 оны 08 дугаар сарын 07-ны 15/ 219 тоот албан бичиг, Авилгатай тэмцэх газрын 2015 оны 07 дугаар сарын 09-ны 05/4792 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн Төвлөрсөн дулаан хангамж хариуцсан мэргэжилтнээр Очирбатын Батмөнхийг Нийслэлийн төрийн албаны салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсний дагуу 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдрөөс уг албан тушаалд томилсугай.

2. Ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын ахлагч:	Б.Энхбаяр	Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Гишүүд:	Э.Уянга	Хууль, эрх зүйн мэргэжилтэн
	Я.Гантуяа	Бичиг хэргийн ажилтан
	Г.Мөнхчулуун	Архивын ажилтан
	Б.Халиун	Нярав

2. О.Батмөнхийн үндсэн цалинг албан тушаалын ТЗ-6 зэрэглэлийн 1 дүгээр шатлал буюу 547759 /таван зуун дөчин долоон мянга долоон зуун тавин есөн/ төгрөгөөр тогтоон унаа хоолны нэмэгдлийг зохих журмын дагуу олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД  
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА

Б.БАДРАЛ

УХА0501 9/7397

D:\backup\_old\_pc\Work documents\doc\tushaal 2015.docx

1110300456